



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/497

Булган сум

┌ Баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа, ┐  
туг өргөх ёслолд шаардагдах зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойн аймгийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа, туг өргөх ёслолд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 3,620,000 (гурван сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
07 дугаар сарын 09-ны/ний өдрийн  
А.А.А. дугаар захирамжийн хавсралт



Баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа,  
туг өргөх ёслолд шаардагдах зардлын төсөв

| д/д                | Зардлын нэр        | Тоо ширхэг            | Нэг бүрийн үнэ | Нийт дүн /төг/ - |
|--------------------|--------------------|-----------------------|----------------|------------------|
| 1                  | 2                  | 3                     | 4              | 5                |
| 1                  | Шатахууны зардал   | 309 л                 | 2,720          | 840,480          |
| 2                  | Хоол, хүнс         | 22 хүн, өдрийн 3 хоол | 30,0000        | 1,980,000        |
| 3                  | Байр               | 1 өрөө, 2 хоног       | 140,000        | 280,000          |
| 4                  | Цагаан идээ, айраг | 65 л                  | 8,000          | 520,000          |
| НИЙТ 3,620,000 төг |                    |                       |                |                  |